Анагаахын суурь боловсролын I дамжааны оюутнуудын суралцах хэв маягийг тодорхойлох

С.Нармандах[1], С.Оюунцэцэг[1], Ц.Уянга[1], Д.Отгонцэцэг[1], Д.Баярмаа[1], С.Наранчимэг[1]

[1]АШУҮИС, БАС, Харилцааны ур чадварын тэнхим
Цахим хаяг: narmandakh@mnums.edu.mn, Утас: 99148074

Түлхүүр үг:

Суралцах хэв маяг
I дамжаа
Заах арга
Харилцан үйлдэл
Хүсэл сонирхол

Товч утга:

Үндэслэл: Аливаа сургалтыг зохион байгуулахад багш хүний суралцагчийн хувийн онцлог, суралцах хэв маягийг харгалзан үзэх асуудал чухал байна. Оюутны хүсэл эрмэлзлэл, гүйцэтгэлийг сайжруулахын тулд заахарга барилыг оюутнуудынхаа суралцах хэв маягт нийцүүлэх явдал юм. **Зорилго:** Анагаахын оюутнууд, тэдний суралцах хэв маягийн харилцаа хамаарлыг судлах. **Арга аргачлал:** Оюутнуудын суралцах хэв маягийг тодорхойлох зорилгоор (Victoria chislett) нарын боловсруулсан өөрийгөө үнэлэх VAK стандарт асуулгаар мэдээлэл цуглуулж судалгааны ажлын үр дүнгийн статистик боловсруулалтыг SPSS 21 програмаар хийж гүйцэтгэсэн. **Үр дүн:** Оюутнуудын суралцах хэв маягийг тодорхойлоход хамгийн өндөр хувийг харааны (38.5%) суралцах хэв маяг эзэлж байна. Харин сонсгол, үйлдэл хослосон суралцах хэв маяг хамгийн бага буюу (3.1%) хувийг эзэлж байна. Суралцах хэв маягийг хүйсээр авч үзэхэд эмэгтэй, эрэгтэй аль аль хүйсэнд онцын ялгаа ажиглагдаагүй, харааны суралцах хэв маяг давамгайлж байна. Харин хараа, үйлдэлхосолсон болон сонсгол үйлдэл хослосон суралцах хэв маягууд бага хувьтай байв. Суралцах хэв маягийг нас, хүйс төгссөн сургуультай харьцуулж үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй.

Үндэслэл: Анагаахын сургуульд суралцаж буй оюутнууд олон төрлийн мэдлэг, ур чадварыг хязгаарлагдмал хугацаанд суралцаж, эзэмших шаардлагатай байдаг.[3,4] Үр дүнтэй суралцах боломжийг олгохын тулд уламжлалт танхимын сургалтаас оюутан төвтэй, асуудалд суурилсан, багаар идэвхитэй суралцахад чиглэсэн сургалтын арга зүйг хэрэглэж, ахиц дэвшил гарсаар байна.[7] Суралцах хэв маяг гэдэг нь үнэн, зөв, цаг хугацаатай, тодорхой ба ямар нэг зорилгын хүрээнд зохион байгуулагдсан, сонирхож буй асуудлын хүрээнд цуглуулсан аливаа зүйлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж тодорхой бус байдлыг бууруулах зорилго бүхий өгөгдлүүдийн дараалал юм.[10] Суралцах хэв маяг нь танин мэдэхүйн, мэдээлэл солилцох, харилцан үйлдлийн гэсэн гурван хэлбэртэй.[16] Хүмүүсийн танин мэдэхүйн үе шат нь өөр байдагтай холбоотой сурах процесс нь өөр өөр байдаг.[18] Оюутныхаа сурах хэв маягийг мэддэг байх нь заах арга зүйг хөгжүүлэх хамгийн чухал зүйл юм.[21] Суралцагч нь суралцах хэв маягаа мэдсэнээр өөрийн дотоод ертөнцөө нээж, өөрийн онцлог, хэрэгцээнд тулгуурлан мэдээлэлийг хүлээж авах учраас суралцагчийн ойлголт төсөөлөл нь өөр хоорондоо ялгаатай байдаг.[22] Сургалтандаа суралцагчдын сурах арга барилд тохирсон шинэ арга барилыг нэвтрүүлэх нь хичээлүүдийн гүйцэтгэлийг дээшлүүлэх, багш тохиромжтой заах арга барилыг сонгох, цаашид хичээлийн хуваарь, багшаа сонгох, суралцагчдад сонголт хийх боломжийг олгох, сургалтын ижил орчинд суралцах нөхцөл бүрдэнэ.[24]

Зорилго: Анагаахын оюутнууд, тэдний суралцах хэв маягийн харилцаа хамаарлыг судлахад зорилго оршино.

Арга аргачлал: Судалгааг аналитик судалгааны нэг агшингийн загвар ашиглан 2020 оны 10-р сараас 2021 оны 1-р сарын 5-ны хооронд хийж гүйцэтгэсэн. Оюутнуудын суралцах хэв маягийг тодорхойлох

зорилгоор (Victoria chislett) боловсруулсан өөрийгөө үнэлэх VAK асуулгаар мэдээлэл цуглуулж SPSS 21 програмыг ашиглан үр дүнг тооцлоо. Үр дүнгийн р утга 0.05-аас бага байх тохиолдолд статистикийн хувьд ач холбогдолтой гэж үзсэн.

Асуумжийн орчуулгын баталгаатай байдлыг тодорхойлсон: Англи – Монгол орчуулж, орчуулгыг хөндлөнгийн үнэлгээгээр Монгол - Англи хэлээр мэргэжлийн орчуулагчаар орчуулгыг хийлгэж орчуулгыг харьцуулан мэргэжлийн багш нараар хянуулан урьдчилсан асуумжийг 6 багшаар бөглүүлж, алдааг зассаны дараа судалгаанд хэрэглэсэн.

Үр дүн: Судалгаанд АШУҮИС-ийн суурь боловсролын 1-р дамжааны нийт 557 оюутан хамрагдсанаас 466 буюу (83.8%) эмэгтэй, 90 буюу (16.2%) эрэгтэй оюутан байна. Судалгаанд хамрагдагсдыг насны байдлыг авч үзвэл 41(7.4%) 17-оос доош настай, 433 (77.9%)18 настай, 61 (11.0%) 19 настай, 21 (3.8%) нь 20-иос дээш насны оюутнууд байна. Тэдний амьдрах орчинг авч үзвэл 325 (58.5%) аав, ээжтэйгээ гэртээ, 102 (18.3%) дотуур байранд, 129 (23.2%) нь түрээсийн байр болон хамаатан садныдаа амьдарч байна. Судалгаанд хамрагдсан оюутнуудын зөвхөн 31 (5.6%) нь цагийн ажил эрхэлдэг байв. Бүрэн дунд боловсрол эзэмшилтийг нь авч үзэхэд 214 (38.5%) нь Улаанбаатар хотод, 335 (60.3%) нь аймаг, хөдөө орон нутагт харин 7 (1.3%) нь гадаад улсад бүрэн дунд боловсрол эзэмшсэн байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн байдлын үзүүлэлт

Үзүүлэлт	Тоо	%
Нас		
≤17	41	7.4
18	433	77.9
19	61	11.0
≥20	21	3.8
Хүйс		
Эмэгтэй	466	83.8
Эрэгтэй	90	16.2
Одоо амьдарч буй газар		
Аав, ээжтэйгээ гэртээ	325	58.5
Дотуур байранд	102	18.3
Бусад	129	23.2
Цагийн ажил хийдэг эсэх		
Тийм	525	94.4
Үгүй	31	5.6
Бүрэн дунд боловсрол эзэмшсэн сургууль		
Улаанбаатар	214	38.5
Улсын	111	20.0
Хувийн	103	18.5
Аймаг, орон нутаг	335	60.3
Улсын	278	50.0
Хувийн	57	10.3
Гадаад	7	1.3

Оюутнуудын суралцах хэв маягийг тодорхойлоход хамгийн өндөр хувийг харааны (38.5%) суралцах хэв маяг эзэлж байна. Харин сонсгол, үйл хослосон суралцах хэв маяг хамгийн бага (3.1%) хувийг эзэлж байгааг зураг 1-ээр үзүүлэв.



Зураг 1. Суурь боловсролын 1-р дамжааны оюутнуудын суралцах хэв маяг

Суралцах хэв маягийг хүйсээр авч үзэхэд эмэгтэй, эрэгтэй оюутнуудын аль аль хүйсэнд харааны суралцах хэв маяг давамгайлж байна. Харин хараа, үйл хосолсон болон сонсгол үйл хосолсон суралцах хэв маягууд бага хувьтай байв. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Оюутнуудын суралцах хэв маяг (хүйсээр)

Суралцах хэв маяг	Эмэгтэй		Эрэгтэй	
	Тоо	%	Тоо	%
Харааны	179	38.4	35	38.9
Сонсголын	105	22.5	28	31.1
Үйлийн	117	25.1	20	22.2
Хараа, сонсгол давамгайлсан	28	6.0	3	3.3
Хараа, үйл хосолсон	22	4.7	2	2.2
Сонсгол, үйл хосолсон	15	3.2	2	2.2
Нийт	466	100.0	90	100.0

Харааны хэв маягтай оюутнууд (зураг, диаграм, дүрслэл, жагсаалт гэх мэт) харах эсвэл ажиглах замаар хамгийн сайн сурдаг. Сонсголыг илүүд үздэг суралцагчид лекц сонсох эсвэл бичлэг хийх, сургалтын материалаа хэлэлцэх, өөрсдөөө болон бусадтай сургалтын материалаа ярилцах замаар сурахад хамгийн тохиромжтой ба унших, бичих хэлбэрийн суралцагчид текстэн материалтай харьцах замаар суралцдаг. Суралцах хэв маягийг нас, хүйс төгссөн сургуультай харьцуулж үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй.

Хэлцэмж: Хүний зан төлөв болон сайн талыг таньж хөгжүүлэх, мэддэг зүйлээр нь оролцоог нь нэмэгдүүлж, сурах хэв маягтай нь хослуулах нь цаг хугацааны хувьд эерэг үр дүнг авчирна. Судлаач Fleming Miles нар 1-р дамжааны оюутнуудын дийлэнх нь харааны (чиглэлээр суралцах) хэв маягийг илүүд үздэг, оюутнууд ном,

самбар, сургалтын номон дээрх үгийг харахаар сайн суралцаж мэдээлэл, зааврыг уншвал илүү сайн санаж, ойлгодог гэсэн нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байна. Харааны хэв маягаар сурдаг оюутнууд унших дуртай бөгөөд харааны сэдээлтээс маш их зүйлийг олж авч авдаг байна.

Манай судалгаанд оюутнуудын харах болон сонсож сурах хэв маягийг илүүд үздэг болох нь Felder RM, Spurlin J. нарын анагаахын оюутнууд баримт нотолгоо, зураг, дүрслэл, диаграмм дээр үе шаттайгаар сурахыг илүүд үздэг судалгааны үр дүнтэй ижил байна.

Дүгнэлт: Оюутны сурах идэвхийг нэмэгдүүлэхийн тулд оюутан болон багш нарын зүгээс сурах хэв маягд нь тохируулан сургалтыг зохион байгуулах нь чухал байна. Багшийн зүгээс бүх оюутнуудад хүрч ажиллахын тулд оюутнуудаа ойлгох, олон төрлийн хэв маягаар сургалтаа боловсронгуй болгох нь чухал байна.

Талархал: Хатуу хөл хорионы (COVID-19) үед цахим технологи Google form ашиглан судалгаанд өөрсдийн хүсэлтээр оролцохыг зөвшөөрсөн нийт оюутнууд, хамтран ажилласан багш нартаа баярлалаа.

Ном зүй:

1. *Abidin M, Rezaee A, Abdullah H, Singh K. Learning styles and overall academic achievement in a specific educational system. IJHSS 2011; 1: 143-152. /////1/*
2. *Dunn R, Giannitti MC, Murray JB, Rossi I, Geisert G, Quinn P. Grouping students for instruction: effects of learning style on achievement and attitudes. J SocPsychol 1990;130(4):485–94.*
3. *Romanelli F, Bird E, Ryan M: Learning Styles: A Review of Theory, Application, and Best Practices. American Journal of Pharmaceutical Education 2009, 73:1-5.///8///*
4. *Fleming ND. VARK, a Guide to Learning Styles (online). http://www.vark-learn.com/english/page.asp?p□questionnaire [12 March 2007].///12//*
5. *19. Lie LY, Angelique L, Cheong E. How do male and female students approach learning at NUS? CDTL Brief 7: 1–3, 2004.*
6. *Tariq S, Khan MA, Afzal S, Shahzad SR, Hamza M, Khan HA, et al. Association between academic learning strategies and annual examination results among medical students of King Edward Medical University. Annals of KEMU. 2016; 22(2):124–34.*
7. *Alghasham AA. Effect of students' learning styles on classroom performance in problem-based learning. Med Teach. 2012;34(sup1):S14–S9.*
8. *Felder RM. Matters of style. ASEE Prism. 1996;6(4):18–23.*
9. *Cook DA. Learning and cognitive styles in web-based learning: theory, evidence, and application. Acad Med2005;80(3):266–78.*
10. *Lujan HL, DiCarlo SE. First-year medical students prefer multiple learning styles. AdvPhysiolEduc30: 13–16, 2006.*
11. *Miller P. Learning styles: the multimedia of the mind. Educ Resources Inform Center 451: 140, 2001.*
12. *Tanner K, Allen D. Approaches to biology teaching and learning: learning styles and the problem of instructional selection–engaging all students in science courses. Cell BiolEduc3: 197–201, 2004.*
13. *Hosford CC, Siders WA. Felder-Soloman's index of learning styles: internal consistency, temporal stability, and factor structure. Teach Learn Med. 2010; 22(4):298–303.*
14. *Tariq S, Khan MA, Afzal S, Shahzad SR, Hamza M, Khan HA, et al. Association between academic learning strategies and annual examination results among medical students of King Edward Medical University. Annals of KEMU. 2016; 22(2):124–34.*
15. *Gurpinar E, Bati H, Tetik C. Learning styles of medical students change in relation to time. AdvPhysiolEduc 2011;35(3):307–11.*
16. *Baker CM, Pesut DJ, McDaniel AM, Fisher ML. Evaluating the Impact of Problem-Based Learning on Learning Styles of Master's Students in Nursing Administration. J Prof Nurs 2007;23(4):214–9.*
17. *Coffield F, Moseley D, Hall E, Ecclestone K. Learning styles and pedagogy in post-16 learning: a systematic and critical review. London: Learning & Skills Research Centre; 2004.*
18. *Hosseini SM, Amery H, Emadzadeh A, Babazadeh S. Dental Students' Educational Achievement in Relation to Their Learning Styles: A Cross-Sectional Study in Iran. Glob J Health Sci 2015;7(5):152–8.*
19. *Donche V, Van Petegem P. The development of learning patterns of student teachers: a cross-sectional and longitudinal study. High Educ 2009;57(4):463–75.*
20. *Gurpinar E, Alimoglu MK, Mamakli S, Aktekin M. Can learning style predict student satisfaction with different instruction methods and academic achievement in medical education? AdvPhysiolEduc 2010;34(4):192–6.*
21. *Marriott P. A longitudinal study of undergraduate accounting students' learning style preferences at two UK universities. Account Educ 2002;11(1):43–62.*
22. *Geiger MA, Pinto JK. Changes in learning style preference during a three-year longitudinal study.Psychol Rep 1991;69(3 Pt 1):755–62.*
23. *Koob JJ, Funk J. Kolb's Learning Style Inventory: Issues of Reliability and Validity. Res Soc Work Pract 2002;12(2):293–308.*
24. *Sheehan M, Kearns D. Using Kolb: implementation and evaluation of facilitation skills. IndCommer Train 1995;27(6):8–14.*

To determine thelearning style of first year studentsin basic medical education

Narmandakh S[1], Oyuntsetseg S[1], Uyanga Ts[1], Otgontsetseg D[1], Bayarmaa D[1], Naranchimeg S[1]

[1]MNUMS, School of Biomedicine, Communication Skills of Department
Email: Narmandakh @mnums.edu.mn, Tel:9914-8074

Background: Main role of organizing a course for teachers is to understand their students' learning style and their personal characters.To improve student motivation and performance, teaching methods need to be adapted to the learning style of their students.
Method: Data collected from the VAK standard self-assessment questionnaire developed by Victoria Chislett to determine student's learning styles. Also we have done all results and analyses by SPSS 21.
Results: Visual learning (38.5%) has the highest percentage of students' learning style. However, the combination of listening and kinesthetic style is the lowest (3.1%).
When it comes to learning styles by gender, there is no significant difference between both sexes, and visual learning styles predominate. But there was low percentage of students who has combined skills such as Visual with Kinesthetic and Auditory with Kinesthetic. There were no statistically significant differences in learning styles compared to the age and sex of the graduated from high school.

Key word: Learning, Visual, Auditory, teaching method and teaching style, interaction, interest